







**Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв**

**ОHS-ҮЯЖ1-01**

**ХЭМАБ-ЫН АЮУЛ, ЭРСДЛИЙГ  
ТОДОРХОЙЛОХ, ЗОХИЦУУЛАХ  
ЖУРАМ**

**Улаанбаатар хот  
2022 он**

БОЛОВСРУУЛСАН:	ХЯНАН ЗАСВАРЛАСАН	ХЯНАСАН:	БАТАЛСАН:
Чанарын менежер, халдвар судлаач эмч /ХЭМАБ хариуцсан ажилтан/		ЦЧАБА-ны дарга	ЦССҮТ –ийн захирал
Э.Чагцалдулам		А.Амарзаяа	Н.Эрдэнэбаяр
Огноо:2022.11.30	Огноо:	Огноо:2022.12.02	Огноо:2022.12.02
Гарын үсэг 	Гарын үсэг	Гарын үсэг 	Гарын үсэг  

<b>Агуулга</b>	<b>Хуудас</b>
1. Зорилго	4
2. Хамрах хүрээ	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Үүрэг хариуцлага, эрх мэдэл	4
5. Лавлах иш татсан материал	8
6. Холбогдох баримт	8

## 1. Зорилго

ЦССҮТ-ийн нийт ажиллагсдын ХЭМАБ-тай холбоотой аюулыг илрүүлэх, мэдээллэх, хариу арга хэмжээ авахад зориулагдана.

## 2. Хамрах хүрээ

ЦССҮТ-ийн бүх ажиллагсад ба, холбогдох сонирхогч талуудад хамаарна.

## 3. Нэр томъёо, тодорхойлолт

MNS ISO 9000:2017 Чанарын менежментийн тогтолцооны нэр томъёо тодорхойлолт

MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага

MNS ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо-Шаардлага


MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежмент, удирдамж

**Аюул** гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах аливаа хүчин зүйлс, нөхцөл байдал, үйл ажиллагааг хэлнэ.

**Эрсдэл** гэж аюул тохиолдох магадлал болон тухайн аюул тохиолдсоноос болж гарах эрүүл мэндийн өвчлөл, гэмтлийн хэмжээ буюу үр дагаврын хослолоор илэрхийлэгдэх хэмжигдэхүүнийг хэлнэ.

## 4. АЮУЛЫГ ИЛРҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛЭХ, АРГА ХЭМЖЭЭ АВАХ

**ХЭМАБ-тай холбоотой Аюулын эх үүсвэрийг илрүүлэх, арга хэмжээ авах үйл явцын зураглал**



- Аюулыг аюул мэдээлэх хуудсаар мэдээлнэ.
- ХЭМАБ хариуцсан ажилтан Э.Чагцалдуламд 88098312 утсаар болон лан мессенжерээр аюулыг мэдээлнэ. Аюул мэдээлэх хайрцагийг долоо хоног бүрийн Пүрэв гаригийн 09 цагт нээнэ.

#### 4.1 ТӨВИЙН ЭРСДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Дараах 4 чиглэлийн дагуу эрсдлийн үнэлгээг тодорхойлно.

- **Management-** Удирдлага, зохион байгуулалт
- **Machine-** Тоног төхөөрөмж, машин механизм, технологийн үйл ажиллагаа
- **Media-** Ажлын байрны нөхцөл, орчин
- **Man –** Ажилтны мэдлэг, мэргэжлийн түвшин, ур чадвар

*Эрсдлийн дүн шинжилгээ хийх гэдэг нь эрсдлийн түвшин тогтоох асуудал юм.*

**Эрсдлийн дүн шинжилгээ** - Эрсдлийн түвшний хэмжээнээс хамаарч аюулыг А-аас Е хүртэл 5 зэрэгт хувааж, аюулын ба эрсдлийн түвшинг тогтоосноор эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг дараах байдлаар тодорхойлно.

Аюулын түвшин	Эрсдлийн түвшин R	Аюул, эрсдлийн тодорхойлолт, авах арга хэмжээ
A	R≥100 үл зөвшөөрөгдөх хэмжээний эрсдэл	Эрсдлийн түвшин нь маш өндөр байна. аюулын нөлөөлөл, хүчин зүйлс нь бэртэл, гэмтэл, ноцтой осолд хүргэж болзошгүй учраас ийнхүү өндөр эрсдэлтэй ажлыг эхлэх, гүйцэтгэх ба үргэлжлүүлж болохгүй. Хэрэгжүүлэх арга хэмжээний зардал, өртгөөс үл хамааран эрсдлийг нэн даруй бууруулах арга хэмжээг яаралтай хэрэгжүүлж, эрсдлийн үнэлгээг хийж, аюулыг дахин үнэлэх шаардлагатай.
B	R=51-1000 тохиромжгүй, ихээхэн хэмжээний эрсдэл	Эрсдлийн түвшин нь өндөр байна. Эрсдлийг илүү хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшин хүртэл бууруулах аюулгүй байдлын арга хэмжээг яаралтай авах шаардлагатай. Эрсдлийг бууруулахад чиглэгдсэн хөрөнгийг гаргах шаардлагатай.

C	R=11-50 дундаж хэмжээний эрсдэл	Эрсдлийн түвшин нь дундаж хэмжээтэй байна. хэдийгээр арга хэмжээний яаралтай байдал нь В категорийнх шиг биш ч гэсэн холбогдох хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм дүрмийн дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх шаардлагатай.
D	R=4-10 зөвшөөрөгдөх хэмжээний эрсдэл	Эрсдлийн түвшин нь бага байна. байгууллагын удирдлагын дүгнэлтээр зөвшөөрөгдөж болох эрсдлийн түвшин. Гэвч ажил гүйцэтгэх үед тогтмол хяналт тавьж эрсдлийг удирдах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийг хатуу мөрдлөг болгох шаардлагатай.
E	R=1-3 бага хэмжээний эрсдэл	Эрсдлийн түвшин нь маш бага байна. эрсдлийг бүртгэлд авах, эрсдлийг удирдах хяналтын онцгой арга хэмжээ шаардлагагүй боловч үүнийг 100%-ийн аюулгүй нөхцөл байдлыг хангасан гэж үзэж болохгүй.

#### Хавсралт 1.2

**Эрсдлийн R түвшин-** Утга хэмжээг нь тодорхойлсон P, N, H коэффициентийг ашиглан дээрх томъёоны дагуу тооцоолно.

$$R=P*N*H$$

Тайлбар:

**R-**Эрсдлийн түвшин

**P-**Аюул үүсэх давтамж бүхий магадлалыг тодорхойлох коэффициент

**N-**Аюулаас үүдэх үр дагавар, хор уршгийн хэмжээ бүхий магадлалыг тодорхойлох коэффициент

**H-**Эрсдлийн үнэлгээг хийж буй ажилчдын хувийн саналыг тодорхойлох коэффициент

Уг коэффициентүүдийг болзолт байдлаар тухайн ажлын байран дээрх ажилтнуудаас санал асуулга авах замаар тодорхойлно.



Алхам 1

Аюул үүсэх давтамж бүхий магадлалын P коэффициентийг дараах хүснэгтийн утга, хэмжээг ашиглаж тодорхойлно.

№	Аюул үүсэх магадлал	P коэффициентийн утга
1	Тохиолдлын	1
2	Бага магадлалтай	2
3	Магадлалтай	3
4	Бүрэн магадлалтай	4
5	Тогтмол	5

↓ Алхам 2

Аюулаас үүдэх үр дагавар, хор уршгийн хэмжээ бүхий магадлалын N коэффициентийг дараах хүснэгтийн утга, хэмжээг ашиглаж тодорхойлно.

№	Аюулаас үүдэх үр дагавар, хор уршгийн магадлал	N коэффициентийн утга
1	Хөдөлмөрийн чадвар алдагдах байдалд хүргэхгүйгээр эрүүл мэндэд бага хэмжээний хохирол учруулах гэмтэл	1
2	Эмнэлэгт хэвтэхгүйгээр хөдөлмөрийн чадвар алдагдах байдалд хүргэх бага зэргийн гэмтэл	2
3	Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай ноцтой гэмтэл	3
4	Удаан хугацааны эмчилгээ шаардах хор уршигтай хүнд гэмтэл	4
5	Амь нас эрсдэхэд хүргэх гэмтэл	5

↓ Алхам 3

Эрсдлийн үнэлгээг хийж буй ажилчдын хувийн саналын N коэффициентийг дараах хүснэгтийн утга, хэмжээг ашиглаж тодорхойлно.

№	Ажилчдын хувийн санал	N коэффициентийн утга
1	Аюул, заналын түвшин нь маш бага нөлөөтэй	1
2	Аюул, заналын түвшин нь бага нөлөөтэй	2
3	Аюул, заналын түвшин нь их нөлөөтэй	3
4	Аюул, заналын түвшин нь маш их нөлөөтэй	4
5	Аюул, заналын түвшин нь ноцтой нөхцөл байдал, их хэмжээний сөрөг нөлөөлөл, хор уршигт хүргэж болзошгүй.	5

Н коэффициентийг тодорхойлохын тулд дараах хүчин зүйлүүдийг тооцоолно. Үүнд:

- Осол үүсэх аюулын үйлчлэл, гэмтэл авах хугацаа
- Тухайн ажлын байран дээр гэмтэл авч болзошгүй хүмүүсийн тоо
- Ажилтны тоног төхөөрөмжийг ашиглаж байсан туршлага
- Ажлын сахилга батын түвшин, ажилтнуудын дадал
- Ажлын даалгаврыг гүйцэтгэх үе дэх ажилтны мэргэшил, туршлага, хувийн онцлогийн түвшин
- Ажлын байрны алслагдал, ажил гүйцэтгэхэд хяналт тавих боломж
- Сахилга батыг удирдах боломж, үйлдвэрлэл дээрх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа
- Орчин ба ажлын нөхцлийн нөлөө
- Хохирогчдод анхны тусламж үзүүлэх боломж
- Үйлдвэрлэлийн осолд нөлөөлөх эрсдлийн бусад хүчин зүйлүүд зэрэг.

Эрсдлийн үнэлгээ гэдэг нь ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явц бөгөөд дараах хүснэгтээр эрсдлийн үнэлгээний үр дүнг гаргаж батална.

↓

Тонг төхөөрөмж, ажлын байр, технологийн үйлдэл	Аюулын тодорхойлолт	Аюулын үнэлгээ (коэффициент)			Эрсдлийн түвшин R	Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	Аюулын эцсийн түвшин
		P	N	H			
1	2	3	4	5	6	7	8

### 5. Лавлах, иш татсан материал

MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежмент, удирдамж  
MNS ISO 45001:2018 ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо-Шаардлага

### 6. Холбогдох баримт

Аюул мэдээлэх хуудас



